



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2001 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 4/184

Улаанбаатар хот

Г Буруу үйл, гаж зуршлын гажиг заслын


эмнэлзүйн заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Буруу үйл, гаж зуршлын гажиг заслын эмнэлзүйн заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Зааврын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буяントгох/-т, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д тус тус даалгасугай.
3. Тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

САЙД

С.ЭНХБОЛД



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04  
дүгээр сарын 06-ны өдрийн, дугаар  
тушаалын хавсралт

## БУРУУ ҮЙЛ, ГАЖ ЗУРШЛЫН ГАЖИГ ЗАСЛЫН ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР

### ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтний амьдралын хэв маяг, хоол хүнсний хатуулаг байдал алдагдсанаас хүн байгалиас өөрт зяагдсан зажлах гэдэг төрмөл үйлийг хийх нь багассан байна. Мөн бага наснаасаа хийж сурсан элдэв гаж зуршил нь шүд, эрүү, хоншоорын эрхтэний эмгэг төлөв байдлаар илэрч, шүдний гажиг түүний хүндрэл болох шүдний зуултын гажиг ихсэх үндсэн шалтгаан болж байна /A.10.1/.

Өндөр хөгжилтэй орнуудад хийгдсэн судалгаагаар хүүхдийн шүд, эрүү нүүрний гажгийн дэлхийн дундаж 62-78%, үүнээс шаамий 4,2-6,1%, орсгой 7,0-12%-ийн тархалттай, цаашид өсөх хандлагатай байгааг тогтоожээ.

Манай улсын хувьд НАС-ын гажиг заслын эмчилгээнд хүүхдийн шүдний гажгийг авагддаг зэмсэг (A3), үйл зүйн зэмсэг (Y33), авагддаггүй аппарат (AA) гэсэн 3 аргаар засч байгаагаас A3, AA-аар засах нь дийлэнх хувийг эзэлж байна. Харин өндөр хөгжилтэй орнуудын хувьд Y333 (үйл засах зэмсэг засал)-ийн аргыг нийтлэг хэрэглэдэг.

Y333-ын арга нь буруу үйл, гаж зуршлыг арилган төрмөл үйлийг сэргээх замаар буюу шалтгааныг арилгаж шүдний гажгийг зассанаар нүүр царайны зөв харьцаа бий болгох олон үйлдэл агуулдгаараа бусад аргаас ялгаатай. Хөнгөн хэлбэрийн гажгийн үед Y333-ийг хэрэглэснээр гаижг шууд засагдана. Үүнээс гадна цаашид хүнд хэлбэрийн гажиг үүсэхээс сэргийлнэ.

Хүүхдэд 11 наснаас хойш гажиг заслын авагддаггүй аппаратаар шүдний гажгийг зассан ч гажиг буцах тохиолдол багагүй тохиолддог. Буруу үйл, гаж зуршилтай, төрмөл үйлийн алдагдалтай бол эмчилгээ ийнхүү үр дүнгүй болж болно.

Буруу үйл, гаж зуршил, үйлийн алдагдлаас шалтгаалсан шүдний гажигт Y33-ийг хэдий чинээ бага наснаас хэрэглэнэ гажиг заслын үр дүн төдийчнээ өндөр байна.

Энэхүү зааврыг боловсруулах явцад АНУ, Англи, Япон зэрэг өндөр хөгжилтэй улсын эмнэлзүйн зааврыг судалж, өөрийн орны онцлогт тохируулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулав.

Учир шалтгааны зүй тогтол, шинжлэх ухаанд үндэслэн “Буруу үйл, гаж зуршлын гажиг” (БҮГЗГЗ) хэмээх тодорхойлолтыг Монгол Улсын НАС-ын салбарт анх удаа гаргаж тавив.

Энэхүү заавар нь НАС-ын эмч, мэргэжилтнүүдийн буруу үйл, гаж зуршлын гажиг засал (БҮГЗГЗ)-ын мэдлэгийг дээшлүүлэх гарын авлага төдийгүй уг тусламж үйлчилгээг дэлхийн түвшинд үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн БҮГЗГЗ-ын тусламж, үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжүүлсэнээр нүүр царайны зөв харьцаатай Монгол төрхийг бүрдүүлэн бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулах болно.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АА	авагддаггүй аппарат
А3	авагддаг зэмсэг
БҮГЗГ	буруу үйл гаж зуршлын гажиг
БҮГЗГЗ	буруу үйл гаж зуршлын гажиг засал
ГЗЭ	гажиг заслын эмчилгээ
МЗЭ	мэс заслын эмчилгээ
НАЭА	нүүр амны эрүүл ахуйч
НАХЭ	нүүр амны хүүхдийн эмч
НАЭ	нүүр амны эмчилгээ
НАС	нүүр ам судлал
НАСЗЭ	нүүр амны согог заслын эмч
НАГЗЭ	нүүр амны гажиг заслын эмч
НАМЗЭ	нүүр амны мэс заслын эмч
Ү33	үйл засах зэмсэг
Ү3Д	үйл засах дасгал
Ү3С3	үйл зүйн согог засал
Ү3С33	үйл зүйн согог заслын зэмсэг

## ОРШИЛ


1879 онд Америкийн шүдний эмч Норман эрүүг урагш гүйлгэдэг jumping bite plane зэмсээ танилцуулснаар БҮГЗГЗ (буруу үйл, гаж зуршлын гажиг засал)-ын түүхэнд А үсгээр тэмдэглэгдэн үлдсэн байдаг. 1902, 1906 онд Франц, Дани гм улсаас гараагаа эхлүүлсэн БҮГЗГЗ-ын хөгжилд Европчууд давамгайлах байдалтай байсан бол 1970-аад оноос Америк, Австрали, 1980-аад оны сүүлээс Ази, тэр дундаа Япон улс үүнийг шинжлэх ухаанчаар хөгжүүлж өнөөгийн түвшинд хүрэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.

БҮГЗГЗ нь НАС-ын гажиг заслын салбарын бие даасан институт хэдийн болсон. НАС-ын гажиг заслын эмчилгээнд хүүхдийн шүдний гажгийг үйл засах зэмсэг (Ү33), авагддаг зэмсэг (А3), авагддаггүй аппарат (АА) гэсэн 3 аргаар засч байна. Эдгээр нь гүйцэтгэх үүрэг, зорилгоороо ялгаатай /хүснэгт-1/.

Нэр	нас	Онцлог	үзүүлэх үйлчлэл
Үйл зүйн зэмсэг /Ү33/	4-9	<ul style="list-style-type: none"> <li>- дасах хугацаа /14 орчим хоног/-наас хойш хүүхдэд таагүй мэдрэмж төрүүлэх зүйл байхгүй.</li> <li>Байгалиас заясан төрмөл үйлийг хийлгэснээр:</li> <ul style="list-style-type: none"> <li>- эрүү, хоншиор зөв гольдирлоор өсч хөгжих,</li> <li>зөв гольдролд орсноор шүд зөв байрлалд ургаж гарах,</li> <li>- улмаар зөв харьцаатай нүүр төрх бүрэлдэн тогтох нөхцлийг бүрдүүлэх</li> </ul> </ul>	<p>Төрмөл үйлийг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- сэргээх,</li> <li>- гүйцэд хийлгэх,</li> <li>- зөв хийлгэх</li> </ul> <p>- Гаж зуршлыг арилгах</p>
Авагддаг зэмсэг /А3/	5-13	<ul style="list-style-type: none"> <li>- хуванцар тагнай, металл дэгээ, уруулын нум, тэлэгч пүрш гм олон төрлийн материал орно.</li> <li>- нухах, дарах, холгох тохиолдолд төвөөгшөөх, гадны биет байгаа таагүй мэдрэмж төрөх,</li> <li>- харшил үүсгэж болно,</li> <li>- харшилтай бол зүүх боломжгүй</li> </ul>	<p>Зөөхөн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- түүлхэх,</li> <li>- тэлэх,</li> <li>- татах</li> </ul> <p>гэсэн механик үйлчлэл үзүүлэх</p>
Авагддаггүй аппарат /АА/	12-с хойш	<ul style="list-style-type: none"> <li>- олон төрлийн багаж материал ашигладаг</li> <li>- заавал аль нэг эсвэл хэд хэдэн шүд авч зайд гаргах</li> </ul>	<p>Шүд, яс, холбох эдэд хамгийн зөв хүчээр үйлчлэх,</p> <ul style="list-style-type: none"> <li>- түүлхэх,</li> <li>- тэлэх,</li> <li>- татах</li> </ul>


Ү33, А3, АА-уудыг хэрэглэх үед яригдах асуудал, чиглэх объект нь хоорондоо ялгаатай.

Үйл засах зэмсэг, авагддаггүй аппарат болон авагддаг зэмгийн үед яригдах асуудал, чиглэх объект нь мөн хоорондоо ялгаатай (Хүснэгт-2).



ҮЗГЭЗ-ийн судлаагдахуун нь: буруу үйл, гаж зуршил, төрмөл үйлийн асуудал. Зорилго нь: нь буруу үйл, гаж зуршлыг арилгах, төрмөл үйлийг сэргээх замаар шалтгаантай нь хамт гажигыг засч нүүр царайны зөв харьцаа бий болгоно.

↓                    ↓                    ↓                    ↓                    ↓  
 уруулыг жимиийгэх    хамраар нь амьсгалуулах    зөв залгиулах    зажлах үйл хийгэх    хэлшийг зөв байрлалд аваачих



А3, АА нь гажиг үүссэн шалтгааныг арилгах биш доорх үйлдлийг хийх замаар гагцхүү шүдний гажигыг засах үйлчлэлтэй.

↓                    ↓                    ↓                    ↓  
 зай гаргах, шүд авах    зайнд оруулах, зайнаас гаргах    шүд үрэх, шүд засах    шүдийг дээрээс, доороос татах, шүдийг түлхэх

Байгалиас заясан төрмөл үйлийг хийхгүй байх, дутуу, буруу хийх, бага нааснаасаа олж авсан гаж зуршил нь шүдний ургалт, зуултад нөлөөлж улмаар шүдний гажиг үүсгэх, гажгийн хүндрэл нь эрүү, хоншоорын хөгжилд өөрчлөлт оруулж, нүүрний зөв биш харьцаа бүрэлдэн тогтох гол нөхцөл болдог.

ҮЗ3 нь хүний өөрийн байгалиас заясан үйлийн тогтолцоонд тулгуурлан эрүү, хоншоор ясны өсөлт хөгжлийг зөв чиглүүлэх үйлчлэл үзүүлдэг. Үйлийг сэргээж, гүйцэд зөв хийлгэж гаж зуршлыг арилгаснаар эрүү, хоншоорын харьцаа зөв зүй тогтлоор хөгжих зам нээгдэж, шүд зөв байрлалд ургах, улмаар нүүрний зөв харьцаа бүхий төрх бүрэлдэн тогтдог байна /хүснэгт-3/.

нэр	нас	гажигаас болж нүүр төрхэд орж буй зөв биш харьцаа, өөрчлөлтийг засах	гажиг засах	
			байрлалын	згнээний
үйл зүйн зэмсэг /ҮЗ3/	4-9	тийм	тийм/үсүй	
авагддаг зэмсэг /А3/	5-13	үсүй	тийм	үсүй
авагддаггүй аппарат /АА/	12-с хойш	үсүй	тийм	тийм

## A.УДИРТГАЛ

### A.1 Буруу үйл, гаж зуршлын гажиг (БҮГЗГ)-ийн тодорхойлолт

Буруу үйл, гаж зуршил нь эрүү, хоншоорын ясны өсөлт хөгжил, харилцан зүй тогтолцооны хэвийн төлвийг алдагдуулж шүдний буруу зуулт үүсгэх, улмаар нүүрний зөв биш харьцаа, хэвийн бус төрхөөр илрэн гарах эмгэг буруу үйл, гаж зуршлын гажиг гэнэ.

A.2 Өвчний код /ӨОҮ ангилал Х/ К 07.5, K07.6, F45

A.3 Хэрэглэгчид НАЭА эмч, НАХЭ, НАЭ эмч, НАСЗ эмч, НАГЗ эмч, НАМЗ эмч.

A.4 Зорилго

Хүүхдийн өсөлт хөгжлийн явцад буруу үйл, гаж зуршлын нөлөөгөөр эрүү, хоншоор болон шүдэнд үзүүлэх эмгэг төлөв байдал болох БҮГЗГ-ийг эрт илрүүлэх, оношлох, засах; ирээдүйд үүсэх эрүү, хоншоорын гаж хөгжил, шүдний буруу зуултаас урьдчилан сэргийлэх, багасгах, зөв үйлийг сэргээх, үйл зүйн зөв дадлыг хэвшүүлэх

A.5 Боловсруулсан 2019 он

A.6 Шинэчлэн засах 2029 он

A.7 Эмнэлзүйн заавар боловсруулсан: (хүснэгт-4)

Нэр	Байгууллага	Албан тушаал
Ц.Базаррагчаа /DDs., PhD/ НАЭ эмч, ШТЭ эмч, НАХ эмч, НАГЗ эмч	“Танадент” ХХК Монголын үйл зүйн гажиг заслын холбоо	Захирал Үүсгэн байгуулагч
Г.Насанжаргал	МХХолбоо	Эрхзүйч, хуульч

### A.8 Нэр томьёо, тодорхойлолт

- |                         |                      |
|-------------------------|----------------------|
| 1.Tongue sucking        | хэлээ булталзуулах   |
| 2. Mouth breathing      | амаараа амьсгалах    |
| 3. Bruxism              | шүдээ хавирах        |
| 4.Wrong swallowing      | буруу залгих         |
| 5.Wrong tongue position | хэлний буруу байрлал |
| 6.Thumb, finger sucking | хэл, хуруугаа хөхөх  |
| 7.Lip, cheek biting     | уруул, хацраа зуух   |
| 8.Nail biting           | хумсаа мэрэх         |
| 9.Sleep apnea           | хурхирах             |

### A.9 Тархвар зүй

Буруу үйл, гаж зуршил нь үйлийн гажиг, түүний хүндрэл болох шүдний зуултын элдэв гажиг үүсэхэд нөлөөлэх үндсэн шалтгаан болсоор байна. Энэ нь хожуу үедээ гажиг заслын эмчилгээ хийлгэж шүдний эгнээг зассан ч буцах, үр дүнгүй болох үндсэн нөхцөл болдог.

Буруу үйл, гаж зуршлыг аль болох эрт үед нь илрүүлж оношлох, засах шаардлагатай. Дэлхийн улс орнууд бага насны хүүхдийн дундах энэ төрлийн гажгийн тархалт, ирээдүйн төлвийг судлан тогтоож эмнэлзүйн заавартаа тусгах замаар БҮГЗГ-ийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлж байна. Гадны улс орнуудад 4-9 насны хүүхдийн 68-71% нь эрүү, хоншоорын болон шүдний ямар нэг гажигтай, үүнээс шаамий 4-6%, орсгой 7-12%-ийг эзэлдэг гэсэн судалгаа байна.

2005 онд хийгдсэн Н.Пүрэвжав (АУ-ны доктор) болон бусад эрдэмтдийн хийгдсэн судалгаагаар шаамий 5,3% байсан бол Ц.Базаррагчаагийн 2012 онд хийгдсэн судалгаагаар 6-9 насны 1,380 хүүхдэд хийсэн судалгаагаар шаамий 5,8%-тай болж өссөн, цаашид жилд 1%-иар өсөх магадлалтай гэсэн тооцооллыг гаргасан байна.

2017 онд Ц.Базаррагчаа нарын 3-5 насны 580 хүүхдэд хийсэн судалгаагаар шаамий 6,1 %, орсгой 7,3 %, гүн зуулт 3,2 % байгаа нь 2012 оны "... жилд 1% -иар өсөх магадлалтай..." гэсэн дүгнэлттэй тохирч байна.

Дээрх судалгааны дүн шаамий хэлбэрийн гажиг манай улсад Азийн улсын дунджаас өндөр байгааг харуулж байна.

A.10 Үндсэн ойлголт: Буруу үйл, гаж зуршлын гажгийн олон улсын ангилал

A.10.1 Олон улсын өвчний ангилал. ICD-DA 10 /хүснэгт-5/

Дараах хэлбэрээр илрэн гарах буруу үйл, гаж зуршлын шалтгаантай шаамий, орсгой, заалхай, гүн зуулт, шүдний бөөгнөрлийг буруу үйл, гаж зуршлын гажигт хамааруулж ойлгоно. Үүнд:

<input checked="" type="checkbox"/> амаараа амьсгалах	<input checked="" type="checkbox"/> хоёр хацраа сорох
<input checked="" type="checkbox"/> буруу залгих	<input checked="" type="checkbox"/> хэлээ хөхөх
<input checked="" type="checkbox"/> хөхөө удаан хөхөх	<input checked="" type="checkbox"/> хуруугаа хөхөх
<input checked="" type="checkbox"/> хэлээ булталзуулах	<input checked="" type="checkbox"/> хумсаа мэрэх
<input checked="" type="checkbox"/> дээд доод уруулаа зуух	<input checked="" type="checkbox"/> амандаа юм зуух
<input checked="" type="checkbox"/> амаа ангайх	<input checked="" type="checkbox"/> шанаагаа тулах
<input checked="" type="checkbox"/> шүдээ хавирах	<input checked="" type="checkbox"/> эрүүгээ тулах
<input checked="" type="checkbox"/> хурхирах	<input checked="" type="checkbox"/> буруу суух

A.10.2 Үйл засах зэмсгийн тухай ойлголт

A.10.2.1 Хүүхдийн өсөлт хөгжлийн явцад үүсч бий болсон буруу үйлийг зогсох, гаж зуршлыг арилгахын тулд байгалиас заясан төрмөл үйлийг хийлгэх шаардлагатай. Үүнийг үйл засах зэмсэг (Y33)-ийн тусламжтай гүйцэтгэнэ.

A.10.2.2 Y33 нь төрмөл үйлийг хийлгэх, дутуу, буруу хийж байвал гүйцэд, зөв хийлгэхэд чиглэнэ. Y33 гэдэг нь дээр дурдсан төрмөл үйлийг хийлгэх, гүйцэд хийлгэх, зөв хийлгэх, гаж зуршлыг арилгах механизмийг өөр дээрээ суулгасан хэрэгсэл юм.

A.10.2.3 Y33 хэрэглэснээр: /хүснэгт-6/

<input checked="" type="checkbox"/>	хэлийг зөв байрлалд оруулах,
<input checked="" type="checkbox"/>	зөв амьсгалыг сэргээх,
<input checked="" type="checkbox"/>	зөв зажлуулах,
<input checked="" type="checkbox"/>	хацар, булчингийн үйлдлийг зохицуулах замаар дээд, доод уруулыг жимиийлгэх боломжтой болно.

A.10.2.4 Y33 нь хацар ба уруулын хашлага, хэл байрлах тавцан, шүдний зуултын хавтгай гэсэн үндсэн хэсгээс тогтоно.


A.10.2.5 Y33 нь эрүүл ахуйн шаардлага хангасан, эмнэлгийн зориулалт бүхий силикон материалыаар хийгдсэн байна. БҮГЗГ-ын хэлбэрээс хамаарч Y33 нь олон төрөл байдаг. Y33-ийг зөвхөн НАС-ын эмчийн зааврын дагуу, эмч болон эцэг, эх, асран хамгаалагчийн хяналтан дор хэрэглэнэ.

Б. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ /АЛГОРИТМ/

Б.1 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хүрээ

Б.1.1 БҮГЗГ, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх гол арга нь хүүхдийг аль болох эрт үед нь нүүр амны эмч, нүүр амны хүүхдийн эмчид үзүүлж оношлуулах, зөвлөгөө авах явдал юм.

Б.1.2 Эцэг, эх, асран хамгаалагчийн эрүүл мэндийн боловсрол, амьдралын хэвшил, хэв маяг, хооллолтын байдал зэрэг нь гажиг үүсэхэд шууд бусаар нөлөөлж болно /хүснэгт-7/.




Б.2 Буруу үйл, гаж зуршлын гажиг (БҮГЗГ) үүсэх магадлалтай эсэхийг илрүүлэх оношилгооны дэс дараалал, алгоритм (хүснэгт-8)

Үндсэн шалгуур үзүүлэлт	Хэвийн бус	Хэвийн
гэр бүлийн гишүүдэд шүдний гажигтай хүн байгаа, байсан эсэх		
архаг болон халдварт өвчний талаарх мэдээлэл		
харшлын талаарх мэдээлэл		

гүйлсэн булчирхайн төлөв байдал	-томорсон, -хатангиршсан	
биеийн ерөнхий хөгжил	-сул	
нүүрний төрх байдал /хажуугаас/	-шаамий, орсгой	шулуун
унтах үеийн байдал	-дээш, доош, хажуу тийш харах, ам ангайх, шүдээ хавирах	
хамар битүүрдэг эсэх	-тийм	
хөхөө хөхсөн байдал /cap/	-1 наснаас дээш	
залгилт	-буруу залгидаг	
уруулаа	-жимиийдэггүй	
хэлээ булталзуулдаг эсэх		
хуруугаа хөхдөг эсэх		
эрүүгээ тулдаг эсэх		
хумсаа мэрдэг эсэх		
шанаа тулдаг эсэх		
амандаа юм зуудаг эсэх		
шүлс залгих үеийн хэлний байрлал	-хоншоорын үүдэн шүд- ний харалдаа, -зуултын хавтгайн түв- шинд -зуулт/хавтгайгаас доош -эрүүний үүдэн шүдний харалдаа	
хэлний хэмжээ	-том эсвэл жижиг	
нүүрний хэлбэр эгц урдаас	-тэгш бус	
شاамий		
орсгой		
гүн зуулт		
зөрмөл зуулт		
эрүүний үений төлөв байдал	-дуугардаг, гацдаг, мултардаг	
сүүн зай	ҮҮСЭЭГҮЙ	
диастем	2 мм-с дээш	2мм хүртэл
хэлний хөвч	богино	
уруулын хөвч	богино	

### Б.3 Эмчилгээний алгоритм

(хүснэгт-9)




Б.3.1 ҮЗ33-ийн үйлчлэл хамгийн үр дүнтэй байх 5-9 насанд НАС-ын эмч мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгсний үндсэнд эцэг, эх (асран хамгаалагч) нь эмчийн заасан хугацаанд ирж, өөрсдөө хяналт тавьж тавьж чадна гэж зөвшөөрсөн тохиолдолд ҮЗ33 хэрэглэнэ. ҮЗ33 нь дангаараа бүх төрлийн гажгийг засах боломжгүйг мөн анхааруулж хэлж өгнө.

Б.3.2 Шүд солигдлын 1,2-р үе шатанд эцэг, эх (асран хамгаалагч) нь зөвшөөрсний дараа ҮЗ33-ийн аргыг хэрэгжүүлнэ. Шүд солигдлын 3-р үе шатанд хүүхдийн болон эцэг, эх (асран хамгаалагч)-ийн аль алиных нь саналыг харгалзан үзнэ.

Б.4 Үйлчлүүлэгчийг дараагийн шатлалын туссламж, үйлчилгээнд илгээх зарчим

Б.4.1 Эрт илрүүлгийн явцад хүүхдийг оношилж буруу үйл, гаж зуршилтай эсэхийг тогтоосны дараа эмгэг зүйн оношилгоо хийнэ. ҮЗ33 хийх боломжтой гэж үзвэл доорхи дарааллыг баримтална.



Б.4.2

ҮЗЗ-ийн арга хэрэглэсний дараа шаардлагатай тохиолдолд гажиг заслын эмчид хандаж зөвлөгөө авсны дараа үйлчлүүлэгчид дараагийн арга хэмжээг үргэлжлүүлнэ. Б.4.3 ҮЗЗ-ийн арга нь нэгэнт үүссэн шүдний бүх төрлийн гажгийг засах боломжгүй тул дараагийн шат болох гажиг заслын эмчилгээ (ГЗЭ)-нд шилжүүлнэ.

## В. ҮЙЛДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

### В.1 Буруу үйл, гаж зуршлын гажгийн ангилал (олон улсын өвчний ангилал-ICD-10)

K07.51 Malocclusion due to abnormal swallowing буруу залгилтаас үүсэх гажиг

K07.54 Malocclusion due to mouth breathing амаараа амьсгалснаас үүсэх гажиг

K07.55 Malocclusion due to tongue, lip or finger habits хэл, уруул, хуруугаа хөхсөнөөс үүсэх гажиг

K07.58 Other specified dentofacial functional abnormalities бусад буруу үйл, гаж зуршлаас үүсэх гажиг

K07.59 Dentofacial functional abnormality, unspecified бусад

F45.2 Bruxism шүдээ хавирах

K07.60 Tempromandibular joint pain-dysfunction эрүүний үений үйлийн алдагдлаас үүсэх өвдөлт

K07.61 Clicking эрүүний үе дуугарах

### В.2 Эрсдэлт хүчин зүйл

В.2.1. Насны хязгаартай байдал. Хүүхдийг аль болох эрт эмчид үзүүлж үйлийн болон гаж зуршилтай эсэхийг илрүүлэх

В.2.2. Эцэг, эхийн байнгын хяналт

В.2.3. ҮЗЗ-ийг тасралтгүй, тогтмол зүүх

В.2.4. ҮЗЗ-ийн үзүүлэх үйлчлэл 10-аас дээш насанд буурна.

(зураг 11)



### В.3 Эрүүл мэндийн боловсрол

В.3.1. Эцэг, эхийг ҮЗГ-ын талаар мэдээлэл, мэдлэгтэй болгох

В.3.2. Цэцэрлэгийн багш наарт боловсрол олгох

В.3.3. Нярайн эмч, хүүхдийн эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх

В.3.4. НАЭ эмч, НАХ эмч, НА ЭА эмч, НАСЗ эмч, НАГЗ эмч, НАМЗ эмч нарыг тасралтгүй сургалтанд хамруулах

#### B.4 Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө

B.4.1 Эцэг, эхчүүд дараах зүйлийг зайлшгүй мэдэх шаардлагатай. Үүнд:

B.4.1.1 Хүүхдийнхээ өсөлт, хөгжилт хэвийн, зөв явагдаж буй эсэхийг ажиглаж анзаарч байх


B.4.1.2 Гүйлсэн булчирхай хэвийн, томорсон эсэхийг шалгаж байх

B.4.1.2.1 Хүүхэд зөв амьсгал хийж байгаа эсэхийг анзаарах

B.4.1.2.2 Хамрын салст бүрхэвч хөөсөн, хавагнасан, томорсон эсэхийг чих хамар хоолойн үзлэгээр оношуулах


B.4.1.2.3 Тоос, ургамал, төмөр, силикон гм зүйлийн харшилтай эсэх

B.4.1.2.4 Хоолоо хэрхэн /хурдан, удаан/ идэж байгаа, зажилж залгиж байгаа эсэхийг анзаарч байх /хүснэгт-11/



#### B.5 Зорилтот бүлэг.

B.5.1 БҮЗГЗ-ыг явуулах хамгийн тохиромжтой насанд (5-9), зөв цагт (18:00-07:00) хэрэгжүүлэхэд үр дүн сайн байх өндөр магадлалтай бүлгийг хамруулж ойлгоно. /хүснэгт-12/



#### B.6 Эмгэг онош зүй.

B.6.1 Зорилго: Буруу үйл, гаж зуршлын нөлөөгөөр эрүү, хоншоор, нүүрний төрх хэвийн бус гэж үзсэн үед цаашид эмгэг төлөв байдлыг нарийвчлан тогтоож далд байгаа өөрчлөлтийг илрүүлэн гаргаж баталгаажуулах.

B.6.2 Ерөнхий оношилгоо

B.6.2.1 Зовуурийг тодорхойлох

B.6.2.2 Биеийн ерөнхий болон амны хөндийн өвчлөлийн байдлыг тодорхойлох

### B.6.3 Эрүү нүүрний оношилгоо

B.6.3.1 Эрүү, хоншоорын өсөлт, хөгжлийн хэвтээ чиглэлийн харьцааг тодорхойлох

B.6.3.2 Эрүү, хоншоорын өсөлт, хөгжлийн босоо чиглэлийн харьцааг тодорхойлох

B.6.3.3 Эрүү, хоншоорын өсөлт, хөгжлийн ураг, хойшоо чиглэлийн харьцааг тодорхойлох

### B.6.4 Үйл зүйн оношилгоо

B.6.4.1 Буруу үйл байгаа эсэхийг тодорхойлох

B.6.4.2 Гаж зуршил байгаа эсэхийг тодорхойлох

B.6.4.3 Эрүүний үений үлийн өөрчлөлт байгаа эсэхийг тодорхойлох

B.6.4.4 Хацар, уруулын булчингийн өөрчлөлт байгаа эсэхийг тодорхойлох

### B.6.5 Эмнэлзүйн оношилгоо

B.6.5.1 Нүүрний зураг авах (эгц урдаас, хажуу талаас)

B.6.5.2 Загвар оношилгоо (анхны ирэлтийн, явцын дундах, дуусах үеийн)

B.6.5.3 Амны хөндийн гадна (эгц урд, баруун зүүн), доторх зураг (үүдэн, бага араа, нэгдүгээр их арааны бүлгийн шүднүүдийг хамруулан зуулттай үеийг эгц урдаас, 45 °C-н өнцгөөр баруун, зүүн талаас зураг авах)

### B.6.6 Cephalo metric оношилгоо

B.6.6.1 Panorama оношилгоо (шүдлэлтийн байдал, saatсан шүд, дутуу, илүү шүд байгаа эсэх)

B.6.6.2 Бусад

## B.7 Хяналт ба үнэлгээ (хүснэгт-13)



**Ашигласан материал:**

- 1.Clinical practice guidelines for orthodontics and dentofacial orthopedics .American association of orthodontists 2017.
- 2.American Academy of Pediatric Dentistry. Management of the developing dentition and occlusion in pediatric dentistry. Pediatr Dent 2014.
- 3.Warren JJ, Bishara SE, Steinbock KL, Yonezu T, Nowak AJ. Effects of oral habits' duration on dental characteristics in the primary dentition. J Am Dent Assoc 2001;132 (12):1685-93.
- 4.Guide for commissioning dental specialties-orthodontics. England 2015.
- 5.Managing the developing dental occlusion a guide for dental practitioners. British Orthodontic Society 2010.
- 6.Kano.A: Application of functional orthodontic appliances to treatment of mandibular retrusion syndrome. J.J C. Dent Chl.2009.april.vol14.p45-62.
- 7.Tahereh Jalaly, Farzaneh Ahrari. Effect of tongue thrust swallowing on position of anterior teeth. J Dent Res Dent Clin Dent Prospects.2009. 3/3/ 73-77.
- 8.Keski-Nisula K. Lehto R. Lusa V. Keski-Nisula L. and Varrela J. ( 2003 ) Occurrence of malocclusion and need of orthodontic treatment in early mixed dentition . American Journal of Orthodontics and Dentofacial Orthopedics, 124 , 631 – 638 .
- 9.Grippaudo F. Pantanali F. Paolantonio E.G. Grecolini M.E. Saulle R. La Torre G. and Deli R.( 2013 ) Prevalence of malocclusion in Italian schoolchildren and orthodontic treatment need . European Journal of Pediatric Dentistry, 1 , 314 – 318 .
- 10.Shalish M. Gal A. Brin I. Zini A. and Ben-Bassat Y.( 2013 ) Prevalence of dental features that indicate a need for early orthodontic treatment . European Journal of Orthodontic, 35, 454 – 459 .
- 11.Grippaudo F. Pantanali F. Paolantonio E.G. Grecolini M.E. Saulle R. La Torre G. and Deli R.( 2013 ) Orthodontic treatment timing in growing patients . European Journal of Pediatric Dentistry,14 , 231 – 236 .
- 12.Klocke A. Nanda R.S. and Kahl-Nieke B. ( 2002 ) Anterior open bite in the deciduous dentition: longitudinal follow-up and craniofacial growth considerations . American Journal of Orthodontics and Dentofacial Orthopedic , 122 , 353 – 358 .
- 13.Cozza P. Baccetti T. Franchi L. Mucedero M. and Polimeni . ( 2005 ) Sucking habits and facial hyperdivergency as risk factors for anterior open bite in the mixed dentition . American Journal of Orthodontics and Dentofacial Orthopedics , 128 , 517 – 519 .
- 14.Giuntini V. Franchi L. Baccetti T. Mucedero M. and Cozza P.( 2008 ) Dentoskeletal changes associated with fixed and removable appliances with a crib in open-bite patients in the mixed dentition . American Journal of Orthodontics and Dentofacial Orthopedics, 13 , 70 – 80 .
- 15.Uma B. Dixit and Raghavendra B. Comparison of soft tissue and dental , skeletal characteristics in children with and without of tongue thrusting habit. Contemp Clin Dent. 2013 Jan-Mar 4/1 / 2-6.
- 16.Clinical practice guidelines for orthodontics and dentofacial orthopedics .American association of orthodontists 2017.
17. American Academy of Pediatric Dentistry. Management of the developing dentition and occlusion in pediatric dentistry. Pediatr Dent 2014.
18. Warren JJ, Bishara SE, Steinbock KL, Yonezu T, Nowak AJ. Effects of oral habits' duration on dental characteristics in the primary dentition. J Am Dent Assoc 2001;132 (12):1685-93.